

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ХАМТАРСАН БАГ

ТОВХИМОЛ

4

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ХАМТАРСАН
БАГИЙН ГИШҮҮН СУРГУУЛИЙН
НИЙГМИЙН АЖИЛТНЫ ГАРЫН АВЛАГА



Хүүхдийг Ивээх Сан нь дэлхийн 120 оронд хүүхдийн эрхийн чиглэлээр ажилладаг төрийн бус, олон улсын байгууллага юм. Монгол Улсад 1994 оноос тогтвортой үйл ажиллагаа явуулж, Боловсрол, Хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн засаглал хөтөлбөрүүдийн хүрээнд үйлажиллагаагаа явуулж байна.

©Хүүхдийг Ивээх Сан, 2016 он

Боловсруулсан: Б.Мөнхжаргал
Хянан тохиолдуулсан: Х.Өлзийтунгалаг
Гарын авлагын зургийг Г.Ганбаяр

Хүүхдийг Ивээх Сан
Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
I дүгээр хороо, Аризона төв, 4-р давхар

Шуудангийн хайрцаг:
Төв шуудан, ш/х-1023, Улаанбаатар хот 13, Монгол Улс

Утас: +976-11-329365,
+976-11-329371

Факс: (976-11) 329361

И-Мейл: secretary@savethechildren.mn

Facebook: Save the Children in Mongolia

Twitter: Save the children MN

Вэб: www.savethechildren.mn

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ХАМТАРСАН БАГИЙН ГИШҮҮН СУРГУУЛИЙН НИЙГМИЙН АЖИЛТНЫ ГАРЫН АВЛАГА

ХҮҮХЭД ХАМГААЛАЛ БА СУРГУУЛЬ

Сургууль, цэцэрлэг бол хүүхэд сурч хөгжихөд таатай, аюулгүй, хүүхдэд ээлтэй, хүчирхийлэлгүй орчин байх ёстой. Ийм орчинд л хүүхэд айх айдасгүй, амгалан тайван байж амжилттай суралцаж чадна. Хүүхэд өдөрт сургууль дээрээ 5-аас 6 цагийг өнгөрөөдөг гэж үзвэл өдрийн 1/4 гэсэн үг. Сургууль бол хүүхдийн хоёр дахь гэрч гэх нь бий. Өдөрт өнгөрөөж буй цаг хугацааг нийтэд нь тооцож үзвэл хүн болж төлөвших, хөгжих явцад ямар их цаг хугацааг зарцуулдгийг харж болно. Тиймээс сургууль нь хүүхдийн хувьд маш чухал бөгөөд хамгийн аюулгүй орчин байх ёстой юм.

Сургууль, цэцэрлэгийн орчинг материаллаг ба материаллаг бус гэж хоёр хуваадаг.

Материаллаг орчин

Материаллаг орчин гэдэг нь сургууль, цэцэрлэгийн барилга байгууламж, анги танхим, бие засах газар, биеийн тамирын заал, номын сан, сургууль дотор амрах суудал, сургуулийн автобус, сургуулийн дэргэдэх талбай, дотуур байр зэрэг бусад үйл ажиллагаа явагдах орчин бөгөөд мөн сургалтын хөтөлбөр, сурах бичиг, хичээлийн бусад хэрэглэгдэхүүнүүд орно.

Материаллаг бус орчин

Сургуулийн материаллаг бус орчин нь нийгэм, сэтгэл зүйн харилцааны болон сургуулийн ардчилсан уур амьсгалыг хэмжиж байдаг маш чухал орчин юм.

Хүүхдийн сурч боловсорч буй орчин нь ямар байвал хүүхэд хамгаалагдаж чадах вэ?

- Хүүхдийн эсэн мэнд амьдрах, сурч хөгжих аюулгүй байдлыг бүрдүүлсэн байх
- Бүхий л орчин гэрэлтүүлэгтэй байх, ил тод харагдахуйц байх
- Сургуулийн барилга байгууламж, анги танхим болон бусад бүхий л орчин хүчирхийлэл үйлдэгдэхгүй байхаар орчинтой, осол, аюулаас урьдчилан сэргийлсэн зөв хийц, байршилтай байх
- Сургуулийн удирдлага, багш нар, сургуулийн бусад ажилчид сургуулийн орчинд хүүхдийг аюулгүй байлгах үүрэг хүлээдэг, ухамсарладаг байх
- Аюулгүй байдал хэр зэрэг хангагдсан байдалд хяналт шинжилгээ хийдэг байх
- Сургуулийн аюулгүйн зөвлөлд сурагчдын оролцоог хангасан байх
- Сургуулийн орчинд гадны хүмүүсийн мөрдөх дүрэм, заавар боловсруулах, хэрэгжүүлдэг байх
- Хүүхдэд анхны тусламж үзүүлэх боломжтой байх
- Сургуулийн эмч ажилладаг байх

Хүүхдийн хөгжил төлөвшилд сургууль, цэцэрлэгийн материаллаг бус орчны олон хүчин зүйлүүд нөлөөлж байдаг. Үүнд:



Монгол Улс хүүхдийн эсрэг хүчирхийлэл, шийтгэлийг бүх орчинд хуулиараа хориглосон. Боловсролын орчинд бол хүүхдийн эсрэг хүчирхийлэл, шийтгэлийг 2006 онд хуульчилсан. Хэдий тийм боловч багш нь хүмүүжүүлэх нэрийн дор бие махбодын шийтгэл болон сэтгэл санааны дарамт үзүүлэх явдал байсаар байна.

Энэхүү харилцааг зохицуулах, хүчирхийлэл дарамтад өртсөн хүүхдийг хамгаалахад сургуулийн нийгмийн ажилтан чухал үүрэгтэй.

Багш нь суралцагчийн бие махбодод халдах, тэдэнд сэтгэл санааны дарамт үзүүлэх, хувийн нууцыг нь задруулахыг хориглоно.
Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 44.3

Оролцогч улсууд эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч, хүүхдийг асран халамжилж байгаа бусад хүн хүүхдийг бие бялдар, сэтгэл зүйн хувьд бүхий л хэлбэрээр дарамтлах, доромжлох, сөргөөр ашиглах, хайр халамжгүй орхих, зүй бусаар хандах, хэрцгийгээр харьцах, албадан хөдөлмөрлүүлэх буюу бэлгийн хүчирхийллээс хамгаалах зорилгоор хууль тогтоох, захиргааны, нийгмийн болон гэгээрлийн бүхий л шаардлагатай арга хэмжээ авна.
Хүүхдийн эрхийн тухай Конвенцийн 19 дүгээр зүйл

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Эрхийн Хорооноос 2001 оны 4 дүгээр сард “Боловсролын зорилго”-ын тухай Ерөнхий зөвлөмжийг баталж, бие махбод, сэтгэл санааны шийтгэл нь Конвенцод харшилж буйг дахин тэмдэглэж “... Сургуулийн хаалгаар орсноор хүүхдүүд хүний эрхээ алдах ёсгүй. Тиймээс, жишээлбэл, боловсрол олгох үйл явц нь хүүхдийн угаас заяасан нэр төрийг хүндэтгэх замаар Конвенцийн 12 дугаар зүйлийн 1-д заасны дагуу хүүхдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, сургуулийн амьдралд оролцох боломжийг хангасан байх ёстой.

Түүнчлэн, боловсролыг олгох үйл явц нь 28 дугаар зүйлийн 2-т заасны дагуу “дэг журам тогтоох болон хүмүүжил олгоход” тавигдах хатуу хязгаарлалт, шаардлагыг сахиж, сургуульд хүч үл хэрэглэх явдлыг хөхиүлэн дэмждэг байх ёстой. Бие махбод ба сэтгэл санааны шийтгэл хэрэглэх нь хүүхдийн угаас заяасан нэр төрийг ч, сургуулийн дэг журмын талаарх заалтыг ч үл хүндэтгэсэн явдал гэж Хороо өөрийн үнэлэлт дүгнэлтдээ дахин дахин тодорхой заасан ...”¹ байна.

2001 оны 9 дүгээр сард зохион байгуулсан Ерөнхий хэлэлцүүлгийн хоёр дахь өдөр батлан гаргасан “Гэр бүл, сургуулийн орчин дахь хүүхдийн эсрэг хүчирхийлэл”-ийн тухай зөвлөмжид “Конвенцийн заалтуудын дагуу гэр бүл, сургууль дахь бүх төрлийн хүчирхийлэл, түүний дотор дэг журам бий болгох буюу хүмүүжлийн арга хэлбэрээр хэрэглэх хүчирхийллийг, тэдгээр нь хэдий хөнгөн байхаас үл хамааран хориглох зорилгоор яаралтайгаар хууль тогтоомж батлах эсхүл хүчингүй болгох”-ыг Хороо улс орнуудад уриалсан.²

Боловсролын байгууллагын орчинд хүүхдийг хамгаалах үүргийг багш, сургуулийн нийгмийн ажилтан, сургуулийн удирдлага, ажиллагсад хүлээж, хүчирхийлэл, дарамт, дээрэлхэх, мөлжлөг, үл хайхрах байдлаас урьдчилан сэргийлж, хүүхдийн хамгаалагдах эрх зөрчигдсөн тохиолдолд үйлчилгээ үзүүлэх, нөхөн сэргээх, хамгаалах ёстой. Урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хүүхдийн эсрэг үйлдэгдсэн хүчирхийллийг илрүүлэх, мэдээлэх, хамтран ажиллах үйл ажиллагааг ч мөн хариуцна.

Тиймээс сургуулийн нийгмийн ажилтан нь багш, сурган хүмүүжүүлэгч, ажиллагсад, эцэг эхчүүдэд хүүхдийн эрхэд суурилсан аргазүй, хүүхэд хамгаалал, хүмүүжлийн эерэг арга гэх мэт хүүхдийн хөгжил, төлөвшил хүмүүжилд үр дүнтэйгээр нөлөөлөх сургалтуудыг зохион байгуулж, олон нийтийн хандлага, ойлголт, мэдлэгийг тасралтгүй дээшлүүлэх ажлыг гүйцэтгэж байх үүрэгтэй.

Хүүхэд гэдэг утгаараа бүх хүүхэд хүчирхийлэл, дарамт, мөлжлөг, дээрэлхэх, үл хайхрах байдалд өртөх эрсдэлтэй байхаас гадна заримдаа нас, хүйс, угсаа гарал, үндэсний цөөнх, хөгжлийн бэрхшээл, нийгмийн байдал зэргээс шалтгаалан эрсдэл, эмзэг байдал нь нэмэгддэг байна. Иймээс хүүхэд хамгааллын үйлчилгээ, тогтолцоо бүх хүүхдэд чиглэгдсэн байх төдийгүй, илүү өндөр эрсдэлд байгаа хүүхдүүдийн онцлог хэрэгцээг харгалзан, тэдэнд чиглэгдсэн тусгай үйл ажиллагаа байна.

Хүүхдийн эсрэг хүчирхийллийг юугаар ч зөвтгөж болохгүй. Хүчирхийллийн бүх хэлбэрээс урьдчилан сэргийлж болно. НҮБ-ын Хүүхдийн Эрхийн тухай Конвенцийн дагуу хүүхэд бүр бүх төрлийн хүчирхийллээс хамгаалуулах эрхтэй.

Хүүхэд гэр бүлдээ, сургууль дээрээ, халамж асрамжийн төвд, гудамж талбайд, хэвлэл мэдээллийн бүхий л орчинд хүчирхийлэл, дарамт, дээрэлхэх үзэгдэлд өртөж байна.

Мэдээллийн Самбар
Багш нь суралцагчийн бие махбодод халдах, тэдэнд сэтгэл санааны дарамт үзүүлэх, хувийн нууцыг нь задруулахыг хориглоно.
Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 44.3



¹ Хүүхдийн Эрхийн Хороо, Ерөнхий зөвлөмж №1, Боловсролын зорилго, 2001 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр, ХЭК/ЕЗ/2001/1,8-р хэсэг

² Хүүхдийн Эрхийн Хороо, Гэр бүл, сургуулийн орчин дахь хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх Ерөнхий хэлэлцүүлгийн өдөр. 28 дугаар хуралдааны тайлан, 2000 оны 9-10 дугаар сар, CRC/C/III, 701 - 745-р хэсэг.

Иймээс хүүхэд хамгааллын үйлчилгээг хамтарсан багаар үзүүлэх нь хүүхэд түүний гэр бүлд цогц үйлчилгээг үзүүлж, асуудлыг олон талаас харж, оролцож, шийдвэрлэхэд ач холбогдолтой болно.

Хүүхэд хамгааллын үйлчилгээ нь цогц байх хэрэгтэй. Цогц гэдэг нь хүүхдийг хүчирхийлэл, дарамт, мөлжлөг, дээрэлхэх, үл хайхрах байдалд өртөхөөс урьдчилан сэргийлж, олон нийтийн ойлголт хандлагыг сайжруулах үйл ажиллагааг тогтмол явуулдаг, хэрэв хүүхэд эрсдэлд өртвөл хамгаалах, нөхөн сэргээх, үйлчилгээ үзүүлдэг, тухайн үйлчилгээг зохих стандарт шаардлага, дүрэм журмын дагуу хүргэхдээ хамтарсан багаар ажиллаж, хүүхдэд аюулгүй орчинд өсөх боломжийг олгох олон талт үйл ажиллагаа юм.

Нэг хүүхдэд тулгарч буй асуудал нь олон учир шалтгаантай, тухайн асуудлыг шийдэхэд олон салбарын, ялгаатай үйлчилгээнүүд шаардагддаг учир хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд салбар хоорондын уялдаа холбоо чухал.

3.1.12 Сургуулийн нийгмийн ажилтан гэж суралцагч, эцэг эх болон багшийн харилцаа, тэдний нийгмийн асуудлаар үнэлгээ хийх, ганцаарчилсан болон бүлэгт чиглэсэн мэргэжлийн зөвлөгөө өгөх замаар нийгмийн сөрөг үзэгдлээс хүүхдийг урьдчилан сэргийлэх, тэдний төлөвшил, хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг мэргэжилтэнг хэлнэ.

Монгол Улсын Боловсролын тухай хуулиас

“нийгмийн ажилтан” гэж баг, хорооны, сургуулийн, нийгмийн халамжийн, эрүүл мэндийн, бусад салбарт ажиллаж байгаа нийгмийн ажил, үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий мэргэжилтэн, ажилтан, албан тушаалтныг;

Хүүхэд хамгааллын тухай хуулиас

Сургуулийн нийгмийн ажлын үйлчилгээ гэдэг нь хүүхдийг хүчирхийлэл, дарамт, шийтгэл, дээрэлхэх үзэгдэл, ялгаварлал, үл хайхрах байдлаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, хохирсон эрхийг нь нөхөн сэргээх, чадваржуулах, зөвлөх, нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, амьдралд нь нөлөөлж буй хүрээлэн байгаа орчин, хүмүүсийн харилцааг сайжруулах, холбогдох байгууллага, үйлчилгээнд зуучлах, мэдээлэх, боломж нөөцөнд холбож өгөх мэргэжлийн үйл ажиллагаа юм. Боловсролын нийгмийн ажилтны үйл ажиллагааны нийтлэг жишиг 172/592 тушаалын 6 хавсралт 2009.12.31 өдрийн НХХ-ийн сайд, БСШУ–ны сайдын хамтарсан 172/592 тоот тушаалаар Сургуулийн нийгмийн ажилтны ажлын байрны тодорхойлолт батлагдсан. Үүнд:

Ажлын байрны 4 дүгээр үндсэн зорилтын хүрээнд:

1. Хүүхдийг эрсдэлээс хамгаалах, хөгжүүлэх чиглэлээр сургууль, гэр бүл, олон нийт, төрийн ба төрийн бус байгууллагуудын хамтын үйл ажиллагааг удирдлагаар хангах;
2. Эмзэг болон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдэд нийцсэн цогц үйлчилгээ үзүүлэх чиглэлээр хамтарсан багаар ажиллах сүлжээг зохион байгуулж, ажил үүргийн уялдаа холбоог зохицуулах;
3. Нийгмийн ажлын үйлчилгээ шаардлагатай сурагчдыг судлах, оношлох, хүүхдийг эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх, нийгэм-сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр анги удирдсан багш нарт мэргэжлийн зөвлөгөө өгөх;
4. Хамран сургах тойргийн хүүхдийн сургуульд хамрагдалтын тухай мэдээллийг сум, хорооны нийгмийн ажилтан, боловсролын гэгээрэл хөгжлийн төвийн ажилтнуудтай

санал солилцож, сургуульд бүрэн хамруулах, хүүхдийг нийгэмшүүлэх, амьдрах ухааны чадвар эзэмшүүлэх, эмзэг болон эрсдэлд нөхцөлд байгаа хүүхдүүдэд дэмжлэг тусламж үзүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд сургууль, гэр бүл, олон нийт, төрийн ба төрийн бус байгууллагуудын оролцоог дэмжих гэж заасан байдаг.

6 дугаар зүйл. Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал

6.1. Сургалтын байгууллага нь хүүхэд хамгааллын бодлогыг тухайн байгуулагад хэрэгжүүлэхдээ хөтөлбөр, төлөвлөгөө гарган, мөрдөж ажиллана.

6.2. Сургалтын байгууллага, албан тушаалтан, багш, ажилтан нь эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар таамагласан, мэдсэн, илрүүлсэн тохиолдолд Хүүхдийн эрхийн тухай хуулиар үүрэг хүлээсэн оролцогч талуудад заавал мэдээлнэ.

6.3. Сургалтын байгуулагад суралцаж байгаа хүүхэд бүрийг тухайн орчинд бие махбодын шийтгэл, сэтгэл зүйн болон үе тэнгийнхний дарамт, үл хайхрах байдал, гэмт хэрэг, зөрчил, хорт зуршилд өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлэхийн тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

6.3.1. сургалтын байгууллагын багш, ажилтан нь хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга эзэмших;

6.3.2. сургалтын байгууллагын багш, ажилтан нь суралцагчдын эрсдэлт нөхцөлд байгаа эсэхийг үнэлэх, судлах, зөвлөгөө өгөх;

6.3.3. сургалтын байгууллагын багш, ажилтан нь суралцагчдын хоорондын нөхөрсөг бус харилцаа, маргаан, зөрчлийг эвлэрүүлэх, зохицуулах, гэр бүлд нь мэдэгдэх зэргээр урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

6.3.4. хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд хор хохирол учруулж болохуйц үйл ажиллагаа, арга хэмжээнд хүүхдийг оролцуулахгүй байх.

6.3.5. хүүхдийг согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын зүй бус хэрэглээнд донтох байдалд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ авах;

Хүүхэд хамгааллын тухай хуулиас...

Сургуулийн хүүхэд хамгааллын бодлого

Хүүхдэд зүй бус хандах, аливаа дарамт, хүчирхийлэл, мөлжлөг, үл хайхрах, дээрэлхэх явдлаас хамгаалах оновчтой бодлого, бүтэц механизмыг дэмжин, бүх хүүхдийг хамгаалах, хүүхэд хамгааллын сургуулийн бодлогыг тодорхойлох шаардлагатай. Хүүхдийг хамгаалахад төрийн бодлого, хууль эрх зүйн орчин, үйлчилгээ, хүний нөөц, яам, салбаруудын хамтын ажиллагаа, зохицуулалт, мэдээлэл, судалгаа, статистик хэрэгтэйгээс гадна нийгмийн эерэг хэм хэмжээ, нийт иргэдийн ойлголт, хандлага, эерэг зан үйл бэхжих, хүүхэд аюулгүй орчинд хамгаалагдан амьдрахад нэн чухал үүрэг гүйцэтгэнэ.

Сургуулийн хүүхэд хамгааллын бодлого нь олон нийтийн ойлголт, хандлага, зан үйлд нөлөөлөх, хүүхдийг хүндэтгэсэн, нийгмийн үнэт зүйлийг хөгжүүлэхэд албан байгууллага, ажил олгогчдыг татан оролцуулах зорилготой хүүхэд хамгааллын талаар төрөөс барих бодлогын нэг чухал хэсэг болно. Энэ нь ажилтан, албан хаагчдад чиглэсэн байгууллагын дотоод бодлого бөгөөд хүүхдэд учрах эрсдэл, хор нөлөөнөөс сэргийлж, хамгаалахын тулд байгууллага бүр анхаарал тавьж байгааг нотолсон баримт бичиг. Сургуулийн хүүхэд хамгааллын бодлогод хүүхэд бүрт аюулгүй, эерэг орчин бүрдүүлэхийн тулд байгууллага, ажилтнууд, сайн дурын идэвхтнүүд болон бусад холбогдох хүмүүс юуг анхаарах ёстойг тусгаж ажиллана. *Сургуулийн хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэгч нь сургуулийн удирдлагын дэмжлэгтэйгээр сургуулийн нийгмийн ажилтан, багш, ажиллагсад болно.*

Сургууль дээрх хүүхэд хамгаалах бодлого нь хүүхдэд зүй бус хандах бүх хэлбэрээс:

Урьдчилан сэргийлэх

Урьдчилан сэргийлэх үйлчилгээ нь хүүхдийн эрхийг алдагдуулж, эмзэг байдал, эрсдэлд оруулж болзошгүй байгаа шалтгааныг арилгах, багасгах үйл ажиллагаа юм. Урьдчилан сэргийлэх үйлчилгээний бас нэг тал нь сургууль дээр хүчирхийлэл, эрсдэл, дээрэлхэх үзэгдэл гарч болзошгүй нөхцөл байдлыг эрт оношлох, илрүүлэх явдал юм. Энэ нь зарим талаараа урьдчилан мэдэх боломжгүй байдаг боловч багш, ажилтан, эцэг эх, нийгмийн ажилтан, хүүхдүүд эрт үеийн шинж тэмдгийг таниж мэдэж чаддаг байх хэрэгтэй.

Эрт үеийн зарим шинж тэмдгийг дурдвал:

- ✓ Сахилга батын асуудал удаа дараа гаргах
- ✓ Ялгаварлагдах, гадуурхагдах
- ✓ Нийгмээс болон анги танхим, найз нөхөд, гэр бүлээс тусгаарлагдах
- ✓ Хяналтгүй уур бухимдал гаргах
- ✓ Хүчирхийлэл, түрэмгий зан авир гаргах
- ✓ Ямар нэгэн хүчирхийллийн хохирогч болох
- ✓ Архи, тамхи, хорт зуршил хэрэглэх
- ✓ Суралцах сонирхолгүй болох, сурлагын амжилт буурах
- ✓ Өөрчлөлтөд тэвчээргүй байх

Хамгаалах, эрсдлийг бууруулах

Хамгаалах үйлчилгээ нь шинэ нөхцөл байдалд дасан зохицож, түүнийг хөтлөн явуулахад шаардлагатай ур чадварт суралцахад хүүхдэд туслах, тэдний нийгмийн чадвар, чадамжийг дэмждэг. Хүүхдийн аюулгүй байдлыг хангах хамгаалах үйлчилгээний стратеги нь хүүхдийн бие махбод, сэтгэл санаа, хөгжилд ноцтой саад учруулах аюул, эрсдлийг таслан зогсоох, хангахад чиглэдэг.

Нөхөн сэргээх

Нөхөн сэргээх үйлчилгээ нь аливаа хүчирхийлэл, дарамтад өртсөн, бэрхшээлийг даван туулж байгаа хүүхдэд “амьдрах” ирээдүйд нь туслах, өөртөө болон бусдад итгэх итгэлийг дахин бий болгох, одоогийн болон шинээр амьдрах орчинд дасан зохицох, бие даан амьдрахад нь туслах явдал юм. Нөхөн сэргээх үйлчилгээнд хүүхдэд үүссэн сэтгэл санааны цочрол, бие махбодын шарх сорвийг илааршуулах, хүүхдийг хэвийн амьдралд ороход туслах зорилготой бүх төрлийн үйл ажиллагааг багтаана.

Санамж! Сургуулийн нийгмийн ажилтан тухайн хүүхдийн кейсийг өөрөө шийдвэрлэх боломжтой бол хамтарсан багийн бусад гишүүдэд мэдээлэх, хамтрах шаардлагагүй. Харин тухайн хүүхэд түүний гэр бүлийн асуудлыг шийдвэрлэхэд олон талын хамтын ажиллагаа шаардлагатай гэж үзвэл хамтарсан багийн бусад гишүүдэд хандаж хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлнэ.

“Хамтарсан баг” гэж гэр бүлийн болон бусад орчинд үйлдэгдсэн хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчил, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд хариу үйлчилгээ үзүүлэх анхан шатны нэгжийг хэлнэ.

Хүүхэд хамгааллын тухай хуулиас...



Хамтарсан багийн гишүүн сургуулийн нийгмийн ажилтны үүрэг

Сургуулийн хамран сургах тойрогт хэд хэдэн баг/хороо байдаг тул сургуулийн нийгмийн ажилтан нь өөрийн сургуулийн байрладаг нутаг дэвсгэрийн харьяа хороо/баг/сумын хамтарсан багт орно. Хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүн болох сургуулийн нийгмийн ажилтан дараах үүргийг хүлээнэ. Үүнд:




- Гэр бүл ба хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах
- Сурагчдын дунд гэр бүлийн болон хүүхдэд тулгарч болох хүүхдийн эсрэг хүчирхийллийн болзошгүй эрсдлийг тандах судалгаа явуулах
- Сургууль дээр болон сургуулийн ойр орчинд хүчирхийлэл гарахаас урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүдийг боловсруулж хэрэгжүүлэх (тухайн сургуулийн байршил, сурагчдын онцлог зэргээс хамаарч хичээлд ирэх, тарах үеийн аюулгүй байдлыг хангах, орчны гэрэлтүүлгийг сайжруулах, үе тэнгийнхний хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зэрэг хөтөлбөрүүд хэрэгжүүлэх)
- Гэр бүл, олон нийт, сургуулийн хамтын ажиллагааг бэхжүүлэх ажлыг санаачлан зохион байгуулах
- Эцэг эх, багш нарт хүүхэд хүмүүжүүлэх уламжлалт болон орчин үеийн эерэг арга барилын талаар сургалт явуулах, мэдээлэл, зөвлөгөө өгөх
- Үе тэнгийнхний хүчирхийллээс хүүхдийг хамгаалахын тулд эерэг хүмүүжил, харилцааны чиглэлээр сургалт явуулах, дэмжих бүлэг ажиллуулах
- Чиг үүргийнхээ хүрээнд холбогдох хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх

Сургуулийн нийгмийн ажилтан хамтарсан багийн бусад гишүүдтэй хамтран ажиллах нь

Сургуулийн нийгмийн ажилтан эрсдэлд байгаа хүүхдийн талаар таамагласан, мэдсэн, илрүүлсэн тохиолдолд Хүүхдийн эрхийн тухай хуулиар үүрэг хүлээсэн оролцогч тал болох хамтарсан багийн гишүүдэд мэдэгдэнэ. Иймээс сургуулийн нийгмийн ажилтан хамтарсан багт ажиллахад шаардлагатай мэдлэг, чадварыг эзэмшсэн байна.

Сургуулийн нийгмийн ажилтанд зайлшгүй шаардлагатай МЧХ		
<p>Мэргэжлийн хувьд:</p> <ul style="list-style-type: none"> Хууль, эрх зүйн болон нийгмийн ажлын суурь онолын талаар мэдлэгтэй харилцах (танин мэдэхүйн, зан үйлийн, системийн, хүний хөгжлийн, хүмүүнлэгийн, психо-динамик) Нийгмийн ажлын үйлчилгээний талаар чиглүүлэх үүрэгтэй оролцох (нийгэм-сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөө өгөх, дэмжих бүлэгтэй ажиллах, нийгмийн үйлчилгээний байгууллагад холбох, зуучлах гэх мэт) Хүүхэд хамгааллын талаар хүүхдийн гэр бүлтэй хамтран ажиллах, хууль эрх зүйн, боловсролын, сэтгэл зүйн, халамжийн үйлчилгээний талаар зөвлөгөө өгөх 	<p>Чадварын хувьд:</p> <ul style="list-style-type: none"> Нийгмийн ажлын үйлчилгээг хүргэх арга, техникүүд эзэмшсэн байх (өөрөө өөртэйгөө ярилцах, гэрийн даалгавар өгөх, дүр солих, мэдээлэл, зөвлөгөө өгөх, чадваржуулах, харилцаанд гарсан зөрчлийг шийдвэрлэх гэх мэт) Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх талаар мэргэжлийн онцлогоор харилцах, шийдвэр гаргах Хүүхдийн аюулгүй байдлыг үнэлж, үйлчилгээний хөтөлбөр боловсруулах Сургуулийн хүүхдэд ээлтэй байдлыг үнэлэх үнэлгээний арга зүйд суралцах Хүүхэд, гэр бүлийн талаарх уламжлалт болон орчин үеийн хөгжлийн арга зүйд суралцах 	<p>Хандлагын хувьд:</p> <ul style="list-style-type: none"> Хүүхдийг ойлгох, хүндлэх, итгэх, зан үйлийг үнэлэх, өөрийн болон хүүхдийн талаар аливаа үйлдэлдээ хариуцлагатай хандах Хүүхдийн эрхэд суурилсан, хүүхэд төвт хандлага, хүүхдийн эрх, хүүхдийн амьдралд гарах өөрчлөлтийг мэдрэх зэргээр хамтран ажиллах Хүүхдийн нууцыг хадгалах, ялгаатай байдлыг хүндэтгэн үзэх, мэргэжлийн хил хязгаарыг барих

Сургуулийн нийгмийн ажилтан хамтарсан багийн бусад гишүүдтэй хамтран үйлчилгээ хүргэхдээ хүүхэд хамгааллын дараах үе шат³-ын дагуу ажиллана.



³ Хүүхэд хамгааллын үйлчилгээний үе шатыг хамтарсан багаар хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх нь, А.Батхишиг, С.Энхтуяа, УБ, 2011, 50–р хуудас

Сургуулийн нийгмийн ажилтан өөрийн сургуулийн хамран сургах тойргийн хүүхдийн асуудлаар амьдран суугаа хорооны хамтарсан багтай ажиллана. Хууль, эрх зүйн үүднээс сум/хороо/багийн Засаг дарга, нийгмийн ажилтан, хэсгийн байцаагч, өрхийн эмч нь хуулийн дагуу хүүхдийг хамгаалах үүрэгтэй.

19 дүгээр зүйл. Хүүхдийн эрхийн ажилтан, нийгмийн ажилтны хүүхэд хамгааллын чиглэлээр явуулах үйл ажиллагаа

19.1 Орон нутгийн хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн байгууллагын нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

- 19.1.1. эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг судлан тогтоох, бүртгэх, тэдний эрх ашгийг хамгаалах, хариу үйлчилгээнд хамруулах;
- 19.1.2. хүүхэд хамгааллын тухай хуулийг сурталчлах, хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх,
- 19.1.3. нөхцөл байдлын үнэлгээ хийж, дүгнэлт гаргах;
- 19.1.4. нөхцөл байдлын үнэлгээг үндэслэн хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг үзүүлж, дуусах хүртэл хүүхдийг хамгаалах;
- 19.1.5. хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын хууль тогтоомж зөрчсөн талаар мэдээлэх, уг зөрчлийг арилгуулахаар шаардлага бичих;
- 19.1.6. эрсдэлт нөхцөлд байгаа, хууль зөрчсөн хүүхдийн талаар бүртгэл, судалгаа хийх, орон нутгийн хүүхэд хамгааллын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх;

20 дугаар зүйл. Нийгмийн ажилтны эрх зүйн байдал


- 20.1. Орон нутгийн хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн байгууллага нь нутгийн өөрөө удирдах байгууллагатай зөвшилцөн сум, дүүрэг, баг, хороонд хүүхдийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан ажиллуулна.
- 20.2. Нийгмийн ажилтны ёс зүйн дүрэм, түүнд тавигдах шаардлагыг тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн мэргэжлийн холбоодтой зөвшилцөн батална.
- 20.3. Нийгмийн ажилтан нь хүүхэд эрсдэлт нөхцөлд байгаа талаарх мэдээлийг хүлээн аваад тухайн газар дээр очиж шалгах, тухайн хүүхэдтэй нөхцөл байдлын талаар харилцан ярилцах, хуулиар хориглоогүй мэдээлэл цуглуулах эрхтэй.
- 20.4. Нийгмийн ажилтан өөрийн амь нас, эрүүл мэндэд аюултай нөхцөлд хүүхдэд эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээ хийх шаардлагатай болсон тохиолдолд цагдаагийн байгууллагын туслалцааг авна.
- 20.5. Нийгмийн ажилтныг ажиллах нөхцөл, боломжоор хангах үүргийг сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга хариуцна.

Хүүхэд хамгааллын тухай хуулиас...

Сургуулийн нийгмийн ажилтан хамтарсан багийн үйл ажиллагааг үр дүнтэй болгоход нийгмийн ажлын үйлчилгээний үе шат тус бүрийг анхаарч ажиллах нь зүйтэй.

Сургуулийн нийгмийн ажилтан үйлчлүүлэгчид /хүүхэд/ үйлчилгээнд хамрагдах ямар нэг асуудал гарч ирвэл тухайн үйлчилгээний байгууллага сургууль, багш, ажилтан нар үйлчилгээ үзүүлэхэд нээлттэй байх болно гэдгийг ойлгуулан хэлээд, хэрэв энэ байгууллагын үйлчилгээний хүрээнд хамрагдахгүй бол зохих байгууллагад холбон зуучлахад нийгмийн ажилтан бэлэн байгаагаа илэрхийлэх хэрэгтэй.

Үйлчилгээний үе шат бүрээр тайлбарлавал:



I. ХАРИЛЦАА ХОЛБОО ТОГТООХ

Сургуулийн нийгмийн ажилтан өөрийгөө үйлчлүүлэгчид /хүүхдэд/ таниулах болон үйлчлүүлэгчийг танин мэдэж улмаар итгэлцэл тогтоох юм. Үйлчлүүлэгч, тэдний гэр бүлийн харилцаа холбоотой танилцах, үйлчлүүлэгчтэй нээлттэй, найдвар бүхий харилцаа тогтооход анхаарах шаардлагатай. Ингэснээр хувь хүмүүс, гэр бүлийн гишүүдэд өөрсдөд нь тулгамдаад байгаа бэрхшээлтэй асуудал, сэтгэл санааг нь зовоож буй зүйлээ нээлттэй ярилцах боломж бүрдэнэ. Харилцаа холбоо тогтооход тусгай харилцааны чадварууд нь сонсох, бусдын сэтгэлийг ойлгох зэрэг чадваруудыг эзэмших хэрэгтэй.



II. НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ ХИЙХ

Нөхцөл байдлын үнэлгээ хийхдээ дараах зүйлийг заавал судалж, үнэлсэн байх шаардлагатай. Үйлчлүүлэгч ба орчны харилцаа холбооны талаар нарийн төвөгтэй мэдээлэл цуглуулна гэсэн үг. Өөрөөр хэлбэл цуглуулсан бүх материал баримтуудын цаана ямар учир шалтгаан байгааг олж тогтоох үйл явц юм.

Нөхцөл байдлын үнэлгээ хийхэд анхаарах зүйлс:

- Хүүхдийн насны онцлогийг харгалзан үзэх
- Бага насны хүүхдүүдийн бодол санаа, мэдрэмж, санаа зовоож буй зүйлс болон үйл ажиллагааг ихэвчлэн зураг дээрээс харж болохыг анхаарах
- Хүүхэд хүмүүсийн хувийн зан байдал, зан төлвийн хэв загварыг тодорхойлох, ерөнхий ажиглалтыг хийх чадвартай байдаг гэдгийг анхаарах
- Ярилцлагын үед эмзэг хөндүүр сэдэв рүү чиглүүлж шахалт үзүүлвэл хүүхэд чимээгүй болох эсвэл харилцаагаа тасалж болохыг анхаарч, мэдрэмжтэй хандах
- Аль болох яагаад гэсэн асуултаас зайлсхийж, нээлттэй асуулт тавьж ярилцах

Мэдээллийг цуглуулах эх сурвалж:

- Үйлчлүүлэгчээс өөрөөс нь асуух
- Гэр бүлийн гишүүдээс асуух
- Найз нөхөд, хөрш, ойр дотны хүмүүсээс асуух
- Бусад байгууллага, мэргэжилтнүүдээс асуух



III. ҮЙЛЧИЛГЭЭГ ТӨЛӨВЛӨХ

Зорилго, зорилтуудаа тодорхойлох

- А. Үйлчлүүлэгч юунд хүрэхийг хүсч байна?
- В. Ямар өөрчлөлт гаргах вэ? Зан байдлын хувьд, хандлагын хувьд, амьдрах болон ажиллах чадварын хувьд гэх мэт
- С. Асуудлыг шийдвэрлэх хувилбаруудыг хамтран дэвшүүлэн эрэмблэх

Үйлчилгээг төлөвлөхөд дараах зүйлийг анхаарна.

- Ямар асуудлыг шийдвэрлэх гэж байгаа
- Ямар үйлчилгээ үзүүлэхээр зорилгоо дэвшүүлсэн
- Ямар үйл ажиллагаа хэрэгжүүлэх
- Нийгмийн ажилтны зүгээс юу хийх
- Үйлчлүүлэгчийн зүгээс ямар үүрэг оролцоотой байх
- Үйлчилгээг хүргэхэд ямар байгууллага, мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах
- Хэр удаан хамтарч ажиллах буюу үйлчилгээ эхлэхээс дуусах хугацаа
- Үйлчилгээ үзүүлэх орчин. Жишээ нь: гэрт нь, сургууль дээр, анги танхимд, оношлогооны болон зөвлөгөөний кабинет гэх мэт
- Уулзалтын давтамж, нэг удаагийн уулзалтын үргэлжлэх хугацаа

IV. ҮЙЛЧИЛГЭЭГ ХҮРГЭХ

Нийгмийн ажлын үйлчилгээг хүргэх үйл явц нь үйлчлүүлэгчийн асуудлыг шийдвэрлэх, тэдэнд дэмжлэг туслалцаа үзүүлэх, дэмжих, чадваржуулах, хөгжүүлэхийн тулд нийгмийн ажилтан мэргэжлийн үйлчилгээ, арга техникийг зайлшгүй хэрэглэнэ. Жишээлбэл: Сурлагын амжилтад саад болж буй нийгэм–сэтгэлзүйн бэрхшээлд үнэлгээ өгөхөд холбогдох багш, ажилтантай хамтарч болно.

- Нийгмийн ажилтан өмнөх шатанд боловсруулсан төлөвлөгөөний дагуу хамтарсан багийн бусад гишүүдтэй хамтран хүүхэд хамгааллын үйлчилгээ, үйл ажиллагааг хүргэнэ.
- Үйлчлүүлэгч болон гэр бүлийн гишүүдийг үйлчилгээнд бүрэн хамруулахад анхаарна.
- Үйлчилгээний үр дүн нь үйлчлүүлэгчийн оролцооноос ихээхэн шалтгаалдаг бөгөөд нийгмийн ажилтан үйлчлүүлэгчийг дэмжих, өөртөө итгэх итгэлийг нь нэмэгдүүлэхэд чиглэсэн байх хэрэгтэй.

Үйлчилгээг хүргэхэд анхаарах зүйлс:

- Уулзалтыг хийхдээ үйлчлүүлэгчид тулгарсан нөхцөл байдал, асуудлын шинж байдлыг харгалзан уулзалтын хугацаа, давтамж, яаралтай уулзах зэргээ зохицуулна.
- Уулзалтыг албан өрөөнд болон үйлчлүүлэгчийн гэрээр зохион байгуулж болно.

Хүүхдэд кейс менежментийн үйлчилгээ үзүүлэх явцад сургуулийн нийгмийн ажилтан нэлээд хэдэн төрлийн үйлчилгээг өөрөө үзүүлэх боломжтой байдаг. Үүнд:

- Гэр бүлд зөвлөгөө өгөх
- Гэр бүлийн хурал, уулзалт хийх
- Хүүхэд болон гэр бүлийн гишүүдийг ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөөнд хамруулах
- Дэмжих бүлэгт хамруулах
- Сөрөг зан үйлийг засах, эерэг зан үйлд сургах
- Бусад нийгэмшихүйн хөтөлбөрт хамруулах зэрэг

V БА VI. ҮЙЛЧИЛГЭЭГ ҮНЭЛЭХ, ТӨГСГӨХ

Сургуулийн нийгмийн ажилтан хамтарсан багтай ажилласнаар үйлчилгээний зорилго хэр биелсэн, төлөвлөсөн үйлчилгээг хүргэж чадсан эсэх, үйлчилгээний явцад үйлчлүүлэгчийг хэрхэн чадваржуулсан, үйлчлүүлэгч болон гэр бүлийн нөөц бололцоог хэрхэн нэмэгдүүлсэн, асуудлыг гэр бүл төвтэйгээр хэрхэн шийдвэрлэж чадсан, үйлчлүүлэгч түүний гэр бүлд гарсан өөрчлөлтүүд, үйлчилгээний үр дүн цаашдаа хэрхэн тогтвортой байх гэх мэт асуудлын хүрээнд үйлчилгээг үнэлнэ.

Сургуулийн нийгмийн ажилтан үйлчилгээг дараах тохиолдолд дуусгаж болно.

- Үйлчлүүлэгч хэвийн нөхцөл байдалд орсон.
- Үйлчилгээний үр дүнд хүүхэд, түүний орчин эерэг байдалд орж, хамгаалагдсан.
- Үйлчлүүлэгч өөр газар руу шилжсэн.

Үйлчилгээг төгсгөх, хаах тухайгаа үйлчилүүлэгчдэд мэдэгдсэн байх хэрэгтэй. Үйлчилгээний төлөвлөгөөг боловсруулж байхдаа л хэзээ хаах, хаахын тулд ямар бэлтгэл хангасан байх тухайг урьдчилан төлөвлөсөн байх ёстой байдаг. Сургуулийн нийгмийн ажилтан үйлчилгээг зогсоосны дараа зургаан сарын хугацаанд үнэлгээ хийдэг. Харин үйлчлүүлэгч хэвийн байдалд ороогүй, кейс нээхэд гарч байсан асуудлуудыг шийдвэрлэж чадаагүй, үйл ажиллагааг хангалттай хэрэгжээгүй тохиолдолд үйлчилгээг үргэлжлүүлнэ.



Сургуулийн нийгмийн ажилтан үйлчилгээг үнэлэх, хаахдаа дараах зүйлийг анхаарна. Үүнд:

- Үйлчилгээ зорилго, зорилтдоо хүрсэн эсэх
- Үйлчлүүлэгчийн сэтгэл санааны байдал хэвийн байдалдаа орсон эсэх
- Үйлчлүүлэгчид хэзээ үйлчилгээ дуусгавар болох талаар мэдээлж, урьдчилан бэлтгэсэн байх
- Кейс хаагдсан ч үйлчлүүлэгч дахин хүсвэл, асуудал гарвал дахин сургуулийн нийгмийн ажилтанд хандаж үйлчилгээ авах боломжтой гэдгийг мэдээлэх хэрэгтэй.

Сургуулийн нийгмийн ажилтан үйлчлүүлэгчийн бие даасан байдлыг хангаж, өөрийн амьдралыг цаашид өөрөө зохицуулан авч явах зан үйлийн болон бусад чадварыг өгөх нь чухал бөгөөд энэ нь тухайн нийгмийн ажилтны мэдлэг, ур чадвараас хамаарна. Сургуулийн нийгмийн ажилтанд тухайн сургуульд суралцдаг, өөр хамран сургах тойргийн хүүхдийн асуудлаар амьдран буй орон нутгийн хамтарсан багийн гишүүдтэй ажиллах хэрэгцээ гарна. Энэ тохиолдолд сургуулийн нийгмийн ажилтан хүүхдийн оршин амьдарч буй тойргийн хамтарсан багийн гишүүдтэй тодорхой хугацаанд холбоотой ажилласны дараа холбон зуучлах, кейс шилжүүлэх үйлчилгээг сонгон ажиллана.

Холбон зуучлах

Хүүхдэд хамгааллын үйлчилгээг хүргэхэд заримдаа сургуулийн нийгмийн ажилтны хүч хүрэхээргүй, өөр мэргэжлийн хүний зөвлөгөө, дэмжлэгийг авах хэрэгцээ гардаг. Тухайлбал, сэтгэл зүйчийн зөвлөгөө авах, зан үйлийн өөрчлөлттэй хүүхэдтэй ажиллах нарийн мэргэжилтний тусламж хэрэгтэй болох гэх мэт. Холбон зуучлахдаа нийгмийн ажилтан дараах арга замыг хайж болно. Үүнд:

- Хүүхэд, тэдний гэр бүлийн хүсэлтийн дагуу үйлчилгээ хүргэх боломжтой байгууллагыг олж хайх
- Тухайн байгууллагын талаар мэдээллийг өгөх
- Үйлчилгээ үзүүлэх нийгмийн ажилтанг зааж өгөх, уулзах өдөр, цагийг товлох
- Нийгмийн ажилтан үйлчлүүлэгчийн цаашдын үйлчилгээний үр дүнг дүгнэх

Холбон зуучилсан байгууллагатайгаа байнга холбоотой байх хэрэгтэй. Мөн холбон зуучлах маягыг ашиглана.

Кейс шилжүүлэх

Шилжүүлэх гэдэг нь тухайн байгууллагын үйлчилгээ үзүүлж байсан нийгмийн ажилтан үйлчлүүлэгчийн асуудал дээр ажилласны дараагаар өөр ажилтанд үйлчлүүлэгчийг шилжүүлэх явдал юм. Энэ нь үйлчилгээний төгсгөлийн үе шатанд хоёр хэлбэрээр яригддаг.

1. Нийгмийн ажилтан үйлчлүүлэгчтэй ажиллах явцад бэрхшээл хүндрэл учирсны улмаас шилжүүлэлтийг хийх
2. Нийгмийн ажилтан өөр байгууллагад шилжин ажиллах тохиолдолд өөрийн үйлчлүүлэгчээ байгууллагын өөр нийгмийн ажилтанд шилжүүлэх гэсэн хэлбэрүүд байж болно.

Кейс шилжүүлэх үед үйлчлүүлэгчид төрж болох өөрчлөлтүүд:

- Үйлчилгээ үзүүлж байсан нийгмийн ажилтан маань намайг үл ойшоолоо, тоосонгүй гэсэн сэтгэгдэл төрж болзошгүй.
- Ганцаардаж эхэлж болно. Үйлчлүүлэгч сургуулийн нийгмийн ажилтантай харилцаж сурсан, арга барил, ажлын хэв маягт дассан байх нь бий.
- Шинэ нийгмийн ажилтан өмнөх ажилтан шиг хандах болов уу, яах бол гэх мэтчилэн олон асуудлууд шилжилтийн явцад тулгардаг.

Нийгмийн ажилтанд төрж болох сэтгэл зүйн өөрчлөлтүүд:

- Үйлчилгээний гэрээгээ зөрчиж байгаа мэт санагдаж мэднэ.
- Үйлчлүүлэгчид нь шинэ нийгмийн ажилтан өөр шиг нь хандаж чадахгүй мэт санагдаж болно.
- Үйлчлүүлэгчээ өрөвдөж, яах бол гэж шаналж мэднэ.

Кейс шилжүүлэн авсан нийгмийн ажилтанд төрж болох өөрчлөлтүүд:

- Өмнөх нийгмийн ажилтан шиг үйлчилгээ үзүүлж чадахгүй байх гэж эргэлзэж болно.
- Үйлчлүүлэгчийг үйлчилгээг авахад бэлэн биш байхад шинэ үйлчилгээнд хурдан шилжих шаардлага гарч болно.



Хүүхдийн оролцоо ба сургуулийн нийгмийн ажилтан

Сургууль, боловсролын орчинд ажиллаж байгаа гэдэг утгаараа сургуулийн нийгмийн ажилтны ажил онцлог ялгаатай. Өдөр бүр хүүхэдтэй ажиллах, харилцаж байгаа тул хүүхдийн хөгжлийн онцлог, ялгаа, нас, биеийн хөгжлийг сайтар таньж мэдэх хэрэгтэй болдог.

Сургууль дээр багш сурагч, сурагч хоорондын, сургуулийн удирдлага багш хоорондын, сургуулийн удирдлага сурагч хоорондын харилцааны гүүр болж, сургууль нь хүүхдэд ээлтэй орчин болгоход чухал үүрэг гүйцэтгэнэ. Үүнд сурагчдын өөрсдийн оролцоог хангах нь хүүхдийн оролцох эрхийг хангаж байгаа хэрэг бөгөөд нөгөө талаар оролцоотой хүүхдүүд өөрсдийгөө хамгаалах, хүчирхийлэл дарамтад өртсөн үед өөрсдийгөө болон найз нөхдөө хамгаалах боломжтой байдаг.

- Сургуулийн нийгмийн ажилтан хамтарсан багаар ажиллахдаа хүүхэдтэй холбоотой асуудал дээр хүүхдийн оролцоог хангахад анхаарлаа хандуулан ажиллах хэрэгтэй.
- Хүүхэд өөрийн амьдралтай холбоотой аливаа шийдвэр гаргахад оролцох эрхтэй.
- Хүүхэд өөртэй нь холбоотой асуудал, үйл ажиллагаанд хүүхэд оролцох, үзэл бодлоо илэрхийлэх чадвартай гэдгийг хүүхэд насны тухай орчин үеийн онолууд нотолж, хүүхдийн оролцох эрхийг Хүүхдийн Эрхийн тухай Конвенцоор баталгаажуулсан.
- Хүүхдийн оролцоо бол тэдний эрх болохоос хариуцлага биш. Хүний эрх, хүүхдийн эрхийн үзэл баримтлалд “хүүхдийн утга учиртай оролцоо” гэж томъёолдог. Хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд оролцох, үгүйгээ тэд өөрсдөө шийдэх эрхтэй.
- Хүүхдийн оролцооны гол санаа нь хүүхдийг хамгаалал, халамж хүртэгч гэсэн уламжлалт үзлээс татгалзаж, хүүхэд бол эрх эдлэгч, өөрчлөлтийг бий болгогч гэж үзэх үзэл юм.

Хүүхдийн утга учиртай, жинхэнэ оролцоо гэдэг нь хүүхдүүд оролцох боломжийн талаар мэдээллийг авч, оролцох эсэхээ өөрсдөө шийдэж, үзэл бодол дуу хоолойгоо өргөж, тэдний санал бодлыг томчууд шийдвэр гаргахдаа харгалзан үзнэ гэсэн үг.

Сургуулийн нийгмийн ажилтан анги удирдсан багштай хамтран ангийнхаа хүүхдийн эрсдэлийг тодорхойлох нь

Анги удирдсан багш нарыг ангийнхаа хүүхдүүдийн эрсдэлийг тодорхойлох арга зүйд суралцуулах, хамтран ажиллах, сургалтыг дэмжих үйл ажиллагаатай холбох нь сургуулийн хүүхэд хамгааллын бодлого, үйл ажиллагаанд зайлшгүй хэрэгцээтэй байна.

Сургуулийн нийгмийн ажилтан, анги удирдсан багш нарт эрсдэл гэж юу вэ, эрсдэл үүсэх хүчин зүйлүүд, /нийгмийн, сургуулийн, гэр бүлийн, хувь хүний зүгээс/ эрсдэлийн түвшинг тодорхойлох, эрсдэлийн хор нөлөө, бууруулах арга зам, түүнчлэн зөрчил, эрсдэл, хүчирхийлэл, шийтгэлийн ялгааг ойлгуулах, чадваржуулах сургалт явуулж, хамтран ажиллах асуудлыг тодорхойлно. Бүлгийн ажил хийж, багш нараар хүүхдийн эрсдэлд орж болох нөхцөлүүдийг тодорхойлуулна.

Хүүхдэд нийгмийн орчноос гарах эрсдэл:

- Автобусаар явж сургуульдаа ирдэг
- Харанхуй гуу жалга, гудамжаар явдаг
- Хичээлээс гадуур хөдөлмөр эрхэлдэг
- РС тоглоом тоглодог
- Цахим орчноос сөрөг мэдээлэл авч ашигладаг
- Томчуудын дарамтад өртдөг гэх мэт

Хүүхдэд сургуулийн орчноос гарах эрсдэл:

- Хоцролт, таслалт гаргадаг
- Ялгаварлан гадуурхагддаг
- Багштай ёс зүйгүй харилцдаг
- Үе тэнгийнхний дарамтад өртдөг
- Оролцоо хангагддаггүй гэх мэт

Хүүхдэд гэр бүлийн орчноос гарах эрсдэл:

- Түрээсийн байр, орц, хонгилд амьдардаг
- Эцэг, эх ажилгүй, орлого багатай
- Гэр бүлийн байдал: салсан, хойд эцэг эх, үрчлэгдсэн
- Эцэг, эхийн хараа хяналт сул
- Эцэг, эх архи, мансууруулах бодис хэрэглэдэг
- Эцэг эх, гэр бүлийн харилцаа сөрөг хандлагатай
- Эрүүл мэндийн байдал гэх мэт

Хүүхдэд хувийн зан чанараас шалтгаалах эрсдэл:

- Дээрэнгүй зантай
- Ганцаардмал, зожиг
- Бүдүүлэг үг, хэллэг хэрэглэдэг
- Бусдыг уруу татдаг
- Архи, тамхи хэрэглэдэг
- Хулгай хийдэг
- Биеэ авч явах байдал

Сургуулийн нийгмийн ажилтан Хүүхэд хамгааллын тухай хуульд заасны дагуу эрсдлийн үнэлгээг анги удирдсан багштай хамтран хийж, бага эрсдэлтэй хүүхэдтэй ангийн багш ажиллах, дунд болон өндөр эрсдэлтэй хүүхэдтэй анги удирдсан багштай нийгмийн ажилтан хамтран ажиллана. Орон нутгийн онцлогоос шалтгаалан хүүхдийн асуудал өөрчлөгдөж болно.

Сургуулийн нийгмийн ажилтан, анги удирдсан багш болгоноос ангийн хүүхдүүдийн эрсдлийн бүлгийн тодорхойлолтыг гаргуулж авсаны дараа сургуулийн хэмжээний нэгтгэлийг хийнэ. Танай сургуулийн 6-12 дугаар ангийн нийт сурагчдын хэдэн хувь нь ямар эрсдэлд хамаарагдаж байгаа, ямар эрсдэл танай сургуулийн хүүхдүүдэд илүү анхаарал татаж байгаа гээд олон зүйлийг судлан гаргаж ажиллана.

Хүүхдийн эрсдлийн бүлгийг тодорхойлон ажилласны үр дүнд:

- Анги удирдсан багш нарын хүүхэд хамгааллын асуудлаарх хандлага өөрчлөгдөнө;
- Хүүхдийг эрсдлээс хамгаалах чадвар нэмэгдэнэ;
- Хүүхдэд тулгамдаж буй олон асуудлын учир шалтгааныг хүүхэд, багш, ажилчид, эцэг эх, сургуулийн удирдлага мэдэрч, тэдний ойлголт нэмэгдэнэ. (хүүхдийн хөдөлмөр, гэр бүлийн хүчирхийлэл, хорт зуршил, цахим орчин дахь хүүхэд хамгаалал, хүүхдийн хөгжил)
- Сургуулийн нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээг ойлгож, үйлчилгээ хүүхдэдээ хүрч, хамтын ажиллагаа идэвхжинэ;
- Хүүхдэд нийгэм сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөө өгөх ур чадварт суралцана;
- Хүүхэд, багш, эцэг эх, олон нийтэд соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэлэлцүүлэг, ярилцлага, чөлөөт уулзалт, уралдаан тэмцээн зэрэг олон хэлбэрээр явуулна.

Жич: Энэ талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Сургуулийн нийгмийн ажилтны нийгэмлэгтэй холбогдож авч болно.

Утас 99168685, байршил СБД 1-р хоро Фламинго төв 6 давхар 602 тоот /1-р төрөхийн урд/

НОМ ЗҮЙ

- УИХ (2006) (2012) Боловсролын тухай" хууль , түүний нэмэлт өөрчлөлтүүд. УБ УИХ (2016). Хүүхдийн эрхийн тухай хууль. УБ
- УИХ (2016). Хүүхэд хамгааллын тухай хууль. УБ
- Х.Өлзийтунгалаг, Н.Оюут–Эрдэнэ, Т.Булганзаяа, Н.Нямдорж, Г.Түмэннаст, Б.Мягмарсүрэн (2006) Нийгмийн ажлын сургалтын материал, УБ
- Х.Өлзийтунгалаг, М.Нямдорж, Т.Цэндсүрэн, Б.Туяа, Б.Мөнхжаргал (2009). Нийгмийн ажлын үйлчилгээ: Боловсролын нийгмийн ажилтны гарын авлага. УБ
- Жоан Дюррант (2007). Хүмүүжлийн эерэг арга, Юу? Яаж?, УБ
- А. Батхишиг, Н. Нямдорж, О. Мягмар (2009). Хүүхэд хамгааллын үйлчилгээ: Нийгмийн ажилтнуудад зориулсан гарын авлага, УБ
- Г. Түмэннаст, Т. Бүрэнжаргал, Н. Болдмаа, М. Батбаатар, Ц. Одгэрэл, Д. Оюунцэцэг, С.Түмэндэлгэр (2015) Хүүхэд хамгааллын хамтарсан багийн өнөөгийн байдал: Судалгааны тайлан, Save the Children Japan, DIPR.
- М. Воодсайд, Т. Маклам, С. Вильсон (2003, 2007) Нийгмийн ажил: Кейс менежмент ба үйл явцын тэмдэглэл, УБ: Копир Тех, ХХК



Хүүхэд хамгааллын тогтолцооны загварыг (хүүхэд хамгааллын хамтарсан багийг) анхан шатны нэгжид (нийслэл, дүүрэг хороонд, орон нутаг сум, багт) бэхжүүлэх зорилгоор Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 23, 27-р хороо, Сонгинохайрхан дүүргийн 2,10-р хороо, Чингэлтэй дүүргийн 9,10-р хороо болон Архангай аймгийн Хайрхан, Батцэнгэл сум, Эрдэнэбулган сумын 4-р багийг сонгон хэрэгжүүлж байна. Тус төсөл нь 2015- 2018 оны хооронд ЖАЙКА-гийн санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжих юм.

Төслийн хүрээнд дараах үйл ажиллагааг явуулна:

Үйл ажиллагаа 1: Хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүдийн чадавхийг бэхжүүлэх

Үйл ажиллагаа 2: Хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүдийн болон салбар дундын байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах

Үйл ажиллагаа 3: Олон нийтийн дунд хүүхэд хамгааллын талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх

Үйл ажиллагаа 4: Төслийн хүрээнд хийгдсэн үйл ажиллагааны сургамж, хүрсэн амжилт, үр дүнд үндэслэн холбогдох яамдад нөлөөлөх

Төслөөс хүлээж буй үр дүн:

- Хамтарсан багийн гишүүд нь мэргэжлийн ур чадвар болон хүүхэд хамгааллын үйлчилгээний арга зүйн мэдлэгээ сайжруулж, зорилтот орон нутаг дахь хүүхдүүдэд хамтарсан багаар хамгааллын үйлчилгээг үзүүлэх боломжтой болсон байна.
- Хүүхэд хамгааллын тогтолцооны хүрээнд байгууллага хоорондын уялдаа холбоо зохицуулалтыг хангах механизм бий болж, бэхжиж хүүхдийн эсрэг хүчирхийллийг эрт илрүүлж, урьдчилан сэргийлэхээс гадна зорилтот орон нутагт хүүхдийн эсрэг хүчирхийллийн эсрэг хариу арга хэмжээг цаг алдалгүй хүргэх боломж нэмэгдэнэ.
- Хүчирхийлэлд өртөх өндөр эрсдэлтэй хүүхдүүд ба тэдний эцэг эх, асран хамгаалагчдын хоорондын харилцааг сайжруулахад дэмжих, хүмүүжлийн эерэг аргыг түгээн дэлгэрүүлнэ.
- Үндэсний болон орон нутгийн түвшин дэх төрийн байгууллагуудын зүгээс хүүхэд хамгааллын үйлчилгээнд ач холбогдол өгч ажиллах нь нэмэгдсэн байна.